

## **БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ**

### **НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР**

#### **1.1. Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны мэдээлэл**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга 9 дүгээр сарын 20-ны өдөр Баян-Өлгий аймагт ажиллалаа.

Төрийн тэргүүнийг аймгийн удирдлагууд угтан авч, төв талбайд цэргийн хүрээ жагсан хүндэтгэл үзүүллээ.

Үүний дараа Алдарт эхийн одон хүртэх эхчүүдийн одонг гардуулж, иргэдтэй уулзалт хийв. Мөн орон нутгийн зарим байгууллагаар орж үйл ажиллагаатай нь танилцлаа.

УОК-ын Шуурхай штабын дарга, ОБЕГ-ын дэд дарга, хурандаа Б.Ууганбаяраар ахлуулсан ажлын хэсэг Баян-Өлгий аймагт ажиллаж, Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үүрэг бүхий мэргэжлийн байгууллагын албан хаагч нарт цогц сургалтыг энэ сарын 21-нд зохион байгуулав.

Тодруулбал" Ковид-19 халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, цар тахалтай тэмцэх хүч хэрэгслийн бэлэн байдлыг дээшлүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах, хорио цээр, халдвар хамгааллын дэглэм тогтоох, онцгой нөхцөл байдлын үеийн хариу арга хэмжээний тактикийг боловсронгуй болгох зорилгоор Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол улс дахь суурин төлөөлөгчийн газар, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас хамтарсан ажлын хэсэг байгуулагдан "Ковид-19 халдварын цар тахлын үеийн орон нутгийн Шуурхай штаб, шуурхай хариу арга хэмжээний багийг бэлтгэх цогц сургалтыг манай аймгаас эхлэн зохион байгуулав.

Мөн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Монгол улс дахь Суурин төлөөлөгч Сергей Диордица 9 дүгээр сарын 21-нд Баян-Өлгий аймагт ажиллаж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг бэхжүүлэх зорилтын хүрээнд аймгийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж нөхцөл байдалд бодитоор дүгнэлт хийв.

Аймгийн ИТХ-ын ээлжит XI хуралдаан 9 дүгээр сарын 25-ны өдрийн 14 цагт эхэлж, Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит буюу 2016-2020 оны бүрэн эрхийн хугацааны хүндэтгэлийн хуралдаанаа зохион байгуулав.

Энэхүү хүндэтгэлийн хуралдаанд аймгийн Засаг дарга А.Гылымхан 2016-2020 онд аймгийн хэмжээнд хэрэгжүүлсэн бүтээн байгуулалтын ажлын талаар мэдээлэл хийж, аймгийн ИТХ-ын дарга Д.Бауыржан төлөөлөгчдөд хандан хүндэтгэлийн үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарар ахлуулсан, УИХ-ын гишүүд Х.Баделхан, Т.Аубакир, Б.Бейсен, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд А.Ариунзаяа, Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан, Барилга хот, байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, БШУС-ын дэд сайд Г.Ганбаяр, Хөдөлмөр нийгмийн хамгааллын дэд сайд С.Зульфхар, Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тилейхан зэрэг албаны хүмүүсийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг энэ сарын 28-нд Баян-Өлгий аймагт ажиллав.

УИХ-ын даргыг аймгийн удирдлагууд угтан авч, төв талбайд цэргийн хүрээ жагсан хүндэтгэл үзүүлэв. Үүний дараа аймгийн удирдлагууд болон төрийн албан хаагчидтай уулзалт хийж, Монгол Улсыг хөгжүүлэх чиглэлээр УИХ, Засгийн газраас авч хэрэгжүүлж буй урт хугацааны бодлого, үйл ажиллагааг танилцуулж, УИХ-ын намрын чуулганаар “Үндсэн хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийн үзэл санааг бодитоор хэрэгжүүлэх зорилгоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Шүүхийн тухай хууль, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль зэрэг 40 гаруй хуулийг шинэчлэн батлах, нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн тухай онцлон тэмдэглэв.

Мөн төр засгаас хэрэгжүүлж буй бодлого, гаргасан шийдвэрүүдийг бүх шатанд хэрэгжүүлж, төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэхэд онцгой ач холбогдол өгч ажиллахыг анхаарууллаа.

## ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

### 2.1. Хууль хяналтын үйл ажиллагаа

#### 2.1.1. Хууль, эрх зүйн хэлтсийн мэдээлэл

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс нь аймгийн Засаг даргын 75 ширхэг А захирамжийг хянаж, тус *ᠳᠦᠶᠡᠳᠡᠨᠡᠭᠡᠢ* хууль тогтоомжийн лавлах санд хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоол, эрх зүйн хэм хэмжээний актыг шинээр бүртгэж, иргэдээс амаар болон бичгээр гаргасан хүсэлт, өргөдлийг хүлээн авч, 9 хүнд зөвлөгөө өгч үйлчлэв. Мөн согтууруулах ундаа худалдах нөхцөл, шаардлагыг хангаж, улсын тэмдэгтийн хураамж төлсөн 18 дэлгүүрт спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг 2 жилийн хугацаагаар шинээр зөвшөөрөл олгов.

#### 1.Архивын тасгийн мэдээ.

Иргэдээс 41 өргөдлийг хүлээж авч, 269 хадгаламжийн нэгжийг ашиглаж 67 лавлагаа, 73 хуудас баримтыг хуулбараар олголоо.

Байгууллагуудын архив, албан хэрэг хариуцсан 13 хүнд зөвлөгөө өгөв.

Хяналт-шалгалтын төлөвлөгөөний дагуу аймгийн НД-ын хэлтэст хяналт-шалгалт явуулав.

Архивын тасгийн архивч, операторч нарын 9 дүгээр сард хийж гүйцэтгэсэн ажлыг нэгтгэж Архивын ерөнхий газарт явуулсан.

Тус тасагт 28 албан бичиг ирснээс 16 хариутай албан бичгийн хариуг хугацаанд нь өгч, Сэлэнгэ аймгийн архивын тасагт 1 хүний өргөдлийг уламжилсан.

#### 2.1.2. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл /өссөн дүнгээр/

1	Иргэдийн баримт бичгийн зөрчлийн арилгалт хувь	99,9
2	Шилжих хөдөлгөөн хот /шилжиж ирсэн аймаг хотоос/	-
3	Шилжих хөдөлгөөн хот дотор /сум, багаас/	-
4	Гадаад паспорт эзэмшигчдийн тоо	31
5	Шинээр гэрлэлт /тоо/	72
6	Нас баралтын бүртгэл	37
7	Төрсний гэрчилгээний бүртгэл	255
8	Үрчлэлт	6

## 2.1.3. Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээлэл /өссөн дүнгээр/

№	Үзүүлэлт	Тухайн сар	Өссөн дүн
1.	Криминалистикийн шинжилгээний тоо	0	42
2.	Хэргийн газрын үзлэгт оролцсон тоо	18	253
3.	Гутлын мөр	2	42
4.	Тээврийн хэрэгслийн мөр	2	32
5.	Эвдлэгч багажийн мөр	0	3
6.	Биологийн гаралтай ул мөр	3	22
7.	Бусад ул мөр	19	185
7.	Хонгио хошуу	0	31
8.	Гарын дардас	10	116
9.	Гарын мөр	0	17
10.	Шүүх эмнэлгийн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо	38	362
11.	Шүүх эмнэлгийн бэлгийн холбогдолтой шинжилгээний тоо	0	15
12.	Цогцост хийсэн шинжилгээний тоо	6	33
13.	Тусгай шинжилгээ болон химийн шинжилгээний тоо	12	66

## 2.2. Мэргэжлийн хяналтын чиглэлээр

№	Заалт	Биелэлт, хувь тоо
1	Хяналт-шалгалтад хамрагдсан байгууллага, илрүүлсэн зөрчил	Энэ сард нийт 13 байгууллагад хяналт-шалгалт хийсэн.
2	Зөрчил дутагдлын барагдуулалт Оногдуулсан торгууль, шийтгэврийн барагдуулалт	Зөрчлийн барагдуулал 71%-тай байна. 9 дүгээр сарын байдлаар нийт бүртгэгдсэн зөрчлийн тоо 15, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн ба 12 иргэн, 3 аж ахуйн нэгжид нийт 2060,0 мянган төргөгийн торгууль тавьж ажилласан байна. Барагдалт 50%-тай
3	Хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан сургалт арга хэмжээний үр дүн/тоо/	МХБ-ын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "Соёлын төвийн түүх, соёлын хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалтад дотоод хяналтыг хэрэгжүүлэх нь" сэдэвт салбарын сургалтыг зохион байгуулав

## ГУРАВ. ХӨДӨӨ, АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

## 3.Хөдөө аж ахуйн чиглэлээр

Мал аж ахуйн өвөлжилтийн бэлтгэлийг хангах талаар Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоол гарснаас хойш түүнийг үндэслэн аймгийн Засаг даргын 553 тоот захирамж гарч, өвлийн бэлтгэлийг хангуулах ажлын хэсгийг 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус ажлын хэсэг нь 3 удаа хуралдаж, өвөлжилтийн бэлтгэлийн явц, үр дүнгийн талаар хэлэлцэж зохих шийдвэр гарган ажиллаж байна. Засгийн газрын

тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, ХХААХҮ-ийн сайдын зөвлөмж зэргийг бүх сумдын удирдлага, мэргэжлийн байгууллагад хүргүүлэн, биелэлтийг авч эхлээд байна.

Засгийн газрын 2020 оны 19 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын 2020 оны А/583 дүгээр захирамжийг гарган 13 сум, 1 тосгонд хүргүүлсэн.

2019 оны жилийн эцсийн тооллогоор 8989 малчин өрх, 2,192,764 толгой мал тоологдсон. 2020-2021 онд 2,332,563 толгой мал, хонин толгойд шилжүүлснээр 3,719,925 толгой мал өвөлжихөөр урьдчилсан тооцоо гараад байна.

Тус аймаг нь нийт 3.5 сая га бэлчээрийн талбайтай.

Бэлчээрийн ургацын гарц, даац багтаамжийг аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газартай хамтран тогтооход 2020-2021 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг сум, баг бүрээр тодорхойлсон. Нийт нутгийн 50%- д хэвийн 40 орчим хувьд дунд зэрэг, 10%-д муу гэсэн үнэлгээтэй гарсан. Аймгийн хэмжээнд хур бороо ихтэй, ногооны гарц сайн боловч хадлангийн гарц урьд оныхоос бага байна. Хилийн 265 дугаар ангид малчдын хүсэлтийг уламжилж хилийн зурвас газраас малчдад хадлан авах боломжийг бүрдүүлж өгсөн.

Аймгийн хэмжээнд 321,6 мянган толгой малыг дотоодын хэрэгцээнд, 391,0 мянган толгой малыг зах зээлд нийлүүлэхээр тооцоолоод байна.

2020-2021 онд Улсын тусгай хамгаалалттай газарт 720 өрхийн 155828 толгой мал, Хилийн зурвас газарт 459 өрхийн 70605 толгой мал, Аймаг дундын отрын бүс болох Ачит нуурын сав газарт 17 өрхийн 13271 толгой мал, Орон нутгийн тусгай хэрэгцээний Алтанцөгц сумын Шар тэвсэг, Олон нуурт 150 өрхийн 59850 толгой мал, Ховд аймгийн Дуут, Мөнххайрхан, Эрдэнэбүрэн, Увс аймгийн Бөхмөрөн сумын нутагт 608 өрхийн 93165 толгой мал, Аймгийн бусад сумын нутагт 205 өрхийн 98860 толгой мал, нийт 2159 өрхийн 491579 толгой мал оторлохоор тооцоолсон

Аймгийн Засаг даргын захирамжаар малчны түвшинд 65400 тн хадлан, 7900 тн гар тэжээл бэлтгэх төлөвлөгөө өгөгдсөн бөгөөд 2020 оны 9 дүгээр сарын 15-ний өдрийн мэдээгээр 48775 тонн хадлан бэлтгэж, биелэлт нь 74,6 хувьтай байна. Харин гар тэжээл 3681 тн, давс, хужир шүү 3384 тн бэлтгээд байна. Энэ жилд ихэнх сумдын хадлангийн ургацын гарц сайтай тул малчдын түвшинд бэлтгэх хадлангийн төлөвлөгөө биелэгдэнэ гэж үзэж байна.

Засгийн газрын 218 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 553 дугаар захирамжаар аймаг, сумын тэжээлийн аюулгүйн нөөцөд 680 тн өвс, 490 тн тэжээл бэлтгэн нөөцлөх ёстой. Үүнээс сумын аюулгүйн нөөцөд 1300 тн өвс, 390 тн тэжээл бэлтгэхээс одоогийн байдлаар 179,0 тн өвс, 17,8 тн тэжээлийн нөөц бүрдүүлсэн ба бусад сумууд нөөцөө бүрдүүлж амжаагүй байна. Гэвч ихэнх сумууд өвс, тэжээл бэлтгэх хөрөнгийн эх үүсвэргүй байна. Иймд сум бүр өөрийн бүх бололцоо, байгаа боломжийг ашиглан өвс тэжээлийн нөөцийг Засгийн газрын тогтоолд заасан хэмжээнд хүргэж бэлтгэх үүрэг өгөгдсөн болно.

Аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд 500 тн өвс, 100 тн тэжээл бэлтгэхээс өнгөрсөн оны үлдэгдэлд 110 тн өвс, 98,8 тн тэжээлийн нөөцтэй. Үлдсэн өвс тэжээл бэлтгэх хөрөнгийн эх үүсвэргүй байна.

Малчид хашаа хороо, уст цэгийн засвараа хийх, хөрзөнг ховхолж, бууцаа нөөцлөх, өвөлжих байшин, хувцас хунар, багаж хэрэгслээ бэлтгэх бүх ажлыг хийж эхэлсэн. Одоогоор 65 хувийн биелэлттэй байна. Мөн мал сүрэгт үзлэг, ангилалтаа

хийлгэж, зах зээлд болон өөрийн хэрэгцээнд хэрэглэх малаа ялган тэмдэглэх, онд орох бүх малдаа дээд зэргийн тарга хүч авахуулах талаар уламжлалт аргаараа өвөлдөө цас дарж, ашиглагдахгүй бэлчээрийг ашиглан намрын отор хийж байна. Мал оторлуулах газаргүй малчдын болон малын тооны судалгааг авч нэгэтгэн үзэхэд Хилийн зурвас газарт 459 өрхийн 70605 толгой мал, Тусгай хамгаалалттай газар нутагт 720 өрхийн 155828 толгой мал байгааг тухайн бүс нутагт мал оруулан оторлуулах хүсэлтийг БОАЖЯ, Хил хамгаалах ерөнхий газарт уламжлаад байна.

Халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд 1109,0 мянган толгой мал хамрагдахаар төлөвлөж, одоогийн байдлаар 879,7 мянган толгой мал хамрагдаж 79,3 хувь, Паразит өвчнийг эмчлэх, сэргийлэх арга хэмжээнд 1500,0 мянган мал хамрагдахаас 1268,0 мянган толгой мал хамрагдаж, 84,5 хувийн биелэлттэй байна. Өвөлжөөний 260,222м<sup>2</sup>, хаваржааны 65755м<sup>2</sup>, уст цэгийн 3146м<sup>2</sup>, агуулахын 11720 м<sup>2</sup>, бүгд 340843м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгдсэн байна.

## **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **4.1. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн чиглэлээр**

Тус аймагт тухайн жилд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар боловсрол болон эрүүл мэндийн салбарт нийт 52,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 35 барилга, засварын төсөл арга хэмжээ 18,7 тэрбум төгрөгөөр санхүүжигдэхээр төлөвлөгдсөн. Одоогийн байдлаар барилга, засварын ажлын нийт гүйцэтгэл 60 хувьтай явж байна. Эдгээр барилга, засварын ажлын барилгын техникийн хяналтыг Барилгын хөгжлийн төв болон аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хамтран хэрэгжүүлж байна. Тухайн жилд аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр 4,8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 18 төсөл арга хэмжээ 2,0 тэрбум төгрөгөөр санхүүжигдэхээр төлөвлөгдсөн. Тайлант хугацаанд нийт гүйцэтгэл 70 хувьтай ба аймгийн Барилга захиалагчийн алба нь барилгын техникийн хяналтын ажлыг гүйцэтгэж байна.

### **4.2. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр**

Тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх хяналт-шалгалт явуулах тухай аймгийн Засаг даргын 2020 оны А/369 дугаар захирамжийн хүрээнд хөдөлгөөнт эргүүл болон Өлгий, Ховд чиглэлийн авто тээврийн хяналтын цэгт 24 цагаар хуваарийн дагуу байгууллагын байгаль хамгаалагчдыг ажиллуулж байна. Тарваган тахал өвчнөөс болон хууль бус агнуурын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, амьтны тухай, хууль тогтоомжуудыг орон нутгийн радио болон цахим хэвлэл мэдээллээр сурталчлах ажлыг зохион байгуулан ажиллаа.

БОАЖСайдтай аймгийн Засаг дарга байгуулсан Байгаль орчныг нөхөн сэргээх, хамгаалах № 20-02 тоот гэрээнд заасны дагуу Ногоон төгөл цэцэрлэгт хүрээлэнд “Мөлдирсу” ХХК-тай гэрээ байгуулж гүн өрмийн худаг гаргуулан усалгааны асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 4 нь аж ахуйн нэгжийн төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргаж, “Өнгөт Маргад” ХХК, “Аумин” ХХК-уудын 2020 оны ус ашиглах дүгнэлт гаргаж хүргүүлэв.

### **4.3. Газрын харилцааны чиглэлээр**

Урд өмчлүүлсэн газрын хэмжээ болон багийн дугаарыг засварлаж 12 иргэнд 10813 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх, нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 19 иргэнд 15142 м2 газрыг гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар өмчлүүлэх 00000 шийдвэр гарсан.

Цахим хэлбэрээр зохион байгуулсан газар эзэмшүүлэх дуудлага худалдааны ялагчаар тодорч газар эзэмших эрхийн гэрчилгээний үнийг бүрэн төлсөн 4 иргэн, 1 аж ахуйн нэгжид 550 м2 газрыг худалдаа үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлэх тухай шийдвэр гарсан.

#### **4.4. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:**

Монгол Улсад мэргэшсэн төрийн албыг бий болгоход дэмжлэг үзүүлэх, төрийн байгууллагад жендэрийн тэгш байдлыг бий болгоход төрийн албан хаагчдын хүлээх үүрэг хариуцлагыг таниулах, төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудын жендэр ба хүний эрхийн мэдлэг, чадавхыг бэхжүүлэхэд зориулагдсан “ЖЕНДЭР БА ХҮНИЙ ЭРХ” сэдэвт сургалтад Бичиг хэрэг, хүний нөөцийн ажилтан оролцов.

Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд байгуулагдан ажиллаж байгаа аймгийн шуурхай штабт жижүүрийн үүрэг гүйцэтгэх хуваарийг гаргаж хавсралтаар хүргүүлэв.

Өлгий Сумын Засаг Даргын 3/296 дугаар албан тоотын дагуу 2020 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсан их цэвэрлэгээнд хуваарийн дагуу нийт ажилчид оролцов. 10 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээг холбогдох газруудад цахим болон бичгээр хүргүүлэв.

#### **4.5. Уул уурхайн чиглэлээр**

Тус аймгийн Бугат сумын “Хатуу” нэртэй талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг “Жол” ХХК-д гурван жилийн хугацаатайгаар олгосон.

“Буянт будаг” ХХК-ийн түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргасныг хянан үзэж уул уурхайн кадастрын системийн прогаммаар бүртгүүлсэн.

Алтай сумын Энгэртийн алтны орд газар “Сагсайн минерал ресурс” ХХК-ийн 7.3 га эвдэрсэн газрыг барьцааны хөрөнгөөр сумын Засаг даргын Тамгын газар, Алтанцөгц сумын Ямаатын алтны орд “Түвшингарав” ХХК-ны 0,55 га, Ногооннуур сумын Хавцлын амны вольфрамын орд “Сунхар” нөхөрлөлийн 2,3 га-д өөрийн хөрөнгөөр тус тус нийт 10,2 га газарт нөхөн сэргээлтийн ажил хийж гүйцэтгэсэн.

### **ТАВ. СУМ, ОРОН НУТГИЙН ТАЛААР**

#### **1. ТОЛБО СУМ**

Энэ сард байгууллагын ажилтан, албан хаагчдын хуралдааныг 2 удаа хийж цаг үеийн байдалтай холбогдуулан үүрэг, даалгавар өгч хэрэгжилтийг ханган ажилласан.

Мөн өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангуулах хүрээнд дээд байгууллагаас ирсэн зөвлөмж, албан бичгийн дагуу холбогдох байгууллага, албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгч ажиллав.

Тус сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2020-2021 оны хичээлийн жилээ эхлэхийн тулд 8 дугаар сар мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж, уг гэрээний дагуу “COVID-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2 удаа халдваргүйтгэл хийсэн. Сургуулийн 80 жилийн ойн баярыг тодорхой төлөвлөгөөний дагуу тэмдэглэн өнгөрүүлэв.

9 дүгээр сард нийт 35 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн ба нийт үзлэг 1012, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 230 байна. Мөн 6 хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн бол 58 хүүхэд дархлаажуулалтад хамрагдсан.

Хөхний үзлэг 95, эсийн шинжилгээнд 9 хүн тус тус хамрагдсан. Элэгний урьдчилан сэргийлэх үзлэгт 48 иргэн үзүүлсэн. Нийгэм даатгалаас өгөх үнийн хөнгөлөлттэй эмийг 31 хүнд өгсөн.

Цусны ерөнхий шинжилгээнд 26 хүн, шээсний ерөнхий шинжилгээнд 41 хүн, ДОХ, тэмбүүгийн шинжилгээнд 10 хүн, элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээнд 30 хүн, сахар тодорхойлох шинжилгээнд 34 хүн, цусны бүлэг тодорхойлох шинжилгээнд 9 хүн тус тус хамрагдсан ба алсын дуудлагад 22 удаа, ойрын дуудлагад 33 удаа тус тус үйлчилсэн. Мөн 6 удаа аймагт олгой болон бусад хүнд өвчтөнийг хүргэсэн.

## **2. АЛТАЙ СУМ**

Сумын Засаг даргын А/23 дугаар захирамжаар Шуурхай штаб байгуулан ажилтан, албан хаагчдын хуваарийг гаргаж, захирамжийн хавсралтаар батлан аймгийн шуурхай штабын 70427049 дугаар утсанд өдөрт 3-4 удаа мэдээлэл өгч ажиллаж байна.

Мал эмнэлгийн ерөнхий газраас өгсөн угаалга, боловсруулалт, тулгалт зэрэг мал амьтны шимэгчтэх өвчнөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг МЭҮН-үүдэд хуваарилж өгсөн болно.

Сумын нутаг дэвсгэрт газар өмчилж, эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын газрын төлбөрийг хуулийн дагуу ногдуулж сумын төсөвт төвлөрүүлж байна.

Шинээр газар эзэмшүүлэх 4 өргөдөл, газрын маргаантай 5 иргэний өргөдөл, гомдлыг тус тус бүртгэж, өвөлжөө, хаваржааны зориулалтаар 2 иргэний эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх засаг даргын захирамжийг үндэслэн газар эзэмших гэрээ байгуулж гэрчилгээ олгов.

Сумын Ерөнхий боловсролын сургуулиуд хичээлийн нээлтээ хийв.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**